



## ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Премиум Нэксус ХК ("Компани")-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("Хурал")-ыг зарлан хуралдуулах асуудлыг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.14 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам болон Компанийн Дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хурлыг 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн 11:00 цагт Монгол Улс, Улаанбаатар 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла Төв, 4-р давхар, Өргөө 3 IMAX-д биечлэн болон <https://hural.cumongol.mn> веб хаягаар Zoom платформ ашиглан цахим хэлбэрээр хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсүгэй. Үүнд:
  - (i) Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
  - (ii) Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн гаргасан дүгнэлтийг батлах;
  - (iii) Компанийн 2024 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгааныг танилцуулах;
  - (iv) ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож дахин томилох.
3. Хурлын зарыг 2025 оны 03-р сарын 21-ний өдөр, давтан зарыг 2025 оны 04-р сарын 05-ны өдөр тус тус өдөр тутмын сонин, Компани болон Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй.
4. Хурлын зар, Хурлаар хэлэлцэх асуудлаар санал өгөх саналын хуудасны загвар, Хурлаас гарах шийдвэр болон Хуралтай холбоотой бусад материалыг тусгасан Хурлын материалыг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
5. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04-р сарын 07-ны өдрөөр тогтсугай.
6. Хурал хуралдуулахтай холбоотой дор дурдсан баримт бичигтэй танилцах боломжийг 2025 оны 04-р сарын 07-ны өдрөөс хувьцаа эзэмшигчдэд олгосугай. Үүнд:
  - (i) Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол;
  - (ii) Хурлын зар;
  - (iii) Хурлаас гарах шийдвэрүүдийн төсөл;
  - (iv) Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
  - (v) Хурлын саналын хуудасны загвар;
  - (vi) Хуралд цахимаар санал өгөх заавар.

7. Хурлын даргаар Гүйцэтгэх захирал А.Ганхуягийг томилсугай.
8. Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр дор дурдсан нэр бүхий ажилтнуудыг томилсугай. Үүнд:
  - (i) Г.Чинзориг, Гүйцэтгэх захирлын орлогч (дарга);
  - (ii) Д.Бүдханд, Конвинеенс дэлгүүрийн бизнесийн Санхүүгийн газрын захирал;
  - (iii) Т.Гантулга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга.
9. Хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
  - (i) Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК-ийн Брокер Ш.Түвшинбаяр (дарга);
  - (ii) Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК-ийн Комплайнс О.Мөнхгэрэл;
  - (iii) Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК-ийн Санхүүгийн шинжээч Б.Марал.
10. Хурлын материалыг 2025 оны 03-р сарын 21-ний өдөр брокерын компаниуд болох Голомт Капитал ҮЦК ХХК болон Апекс Капитал ҮЦК ХХК-д хүргүүлсүгэй.
11. Хуралд санал өгөх хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 2025 оны 04-р сарын 07-ны өдрөөс 04-р сарын 29-ний өдрийн хооронд <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийж, санал өгөх линк, нууц кодыг хувьцаа эзэмшигчдийн гар утсанд илгээсний үндсэн дээр дээрх өдрүүдэд цахимаар хүлээн авахаар шийдвэрлэсүгэй.
12. Хурлын бэлтгэл ажлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, энэ тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
13. Хурлын мэдэгдлийг 2025 оны 03-р сарын 19-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (А.Ганхуяг)-д үүрэг болгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана.)

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХАРААТ БУС ДАРГА:



\_\_\_\_\_ ГАРИ БИОНДО

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

\_\_\_\_\_ *А.ГАНХУЯГ*

А.ГАНХУЯГ

\_\_\_\_\_ *А.ГАНБОЛД*

А.ГАНБОЛД

\_\_\_\_\_ *Г.БАТ-ЭРДЭНЭ*

Г.БАТ-ЭРДЭНЭ

\_\_\_\_\_ *Ч.МӨНХЧИМЭГ*

Ч.МӨНХЧИМЭГ

\_\_\_\_\_ *Г.ЧИНЗОРИГ*

Г.ЧИНЗОРИГ

\_\_\_\_\_ *Б.БАТ-ЭРДЭНЭ*

Б.БАТ-ЭРДЭНЭ

\_\_\_\_\_ *Ө.ЭРДЭНЭЧИМЭГ*

Ө.ЭРДЭНЭЧИМЭГ

\_\_\_\_\_

В.ГАНЗОРИГ